



ДОРНОГОВЬ АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 12/01

Сайншанд сум


“Цахим Дорноговь” хөтөлбөр
батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Технологийн дэвшил, ухаалаг шийдлүүдийг төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд нэвтрүүлж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, цахим засаглалыг бий болгох зорилгоор “Цахим Дорноговь” хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Төрийн болон төрийн өмчит байгууллагын үйл ажиллагааны бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх, нээлттэй, ил тод байдлыг хангах, инновацыг дэмжих, аймгийн нэгдсэн цахим мэдээллийн санг бий болгох, цахим орчинг сайжруулах ажлыг үр дүнтэй зохион байгуулахыг аймгийн Засаг дарга (О.Батжаргал)-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгэм, цахим бодлогын хөгжлийн хорооны ахлагч (У.Энхмаа), аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга (Ц.Батсугир) нарт тус тус даалгасугай.

ДАРГА  Б.ГАНЗОРИГ



“ЦАХИМ ДОРНОГОВЬ” ХӨТӨЛБӨР

Нэг. Үндэслэл

1.1. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Монгол улсын Их Хурлын 2021 оны “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” 106 дугаар тогтоол, “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Цахим үндэстэн” баримтлах чиглэл 2022-2027, “Дорноговь аймгийн 2021-2025 оны стратеги төлөвлөгөө”, “Дорноговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Дорноговь аймгийн Засаг даргын “Хөгжлийн төлөө хамтдаа - II” 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны сайдын 2023 оны А/53 дугаар тушаалын хүрээнд “Цахим Дорноговь” хөтөлбөрийн төслийг боловсруулав.

1.2. Дорноговь аймгийн мэдээллийн технологийн суурь бүтцийг өргөтгөх замаар иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад таниулах, цаг хугацаа болон хөрөнгө оруулалтын бодит нөхцөлд үндэслэн нэн тэргүүнд буюу үе шаттайгаар хийгдэх ажлуудыг энэхүү хөтөлбөрт багтаасан болно.

Хоёр. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

2.1. Орон нутагт цахим шилжилтийг эрчимжүүлж, харилцаа холбоо, мэдээлэл технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр цахим засаглалын хөгжлийг дэмжин төрийн үйлчилгээг иргэдэд түргэн, хүртээмжтэй хүргэх, мэдээллийг шуурхай солилцох, олон төрлийн системийг хооронд нь нэгтгэх, төрөөс иргэнд, төрөөс бизнест, төрөөс төрд үзүүлэх үйлчилгээг чанаржуулах, иргэдийн амьдралд эерэг нөлөө үзүүлэх;

2.2. Орон нутгийн тогтвортой хөгжлийг хангахуйц, мэдлэгт суурилсан эдийн засагт шилжихэд төр, иргэн, бизнесийн зөв харилцааг бий болгоход чиглэсэн, орон нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжих;

2.3. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг систем нэгтгэл, мэдээллийн нэгдсэн орчныг бүрдүүлсэн, инновац, технологийн дэвшилтэд шийдлийг нэвтрүүлэх замаар хэрэгжүүлэх;


2.4. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын орон зай, цаг хугацаанаас үл хамааран төрийн үйлчилгээг түргэн шуурхай авдаг болох;

2.5. Орон нутгийн удирдлага, байгууллагын менежер, шийдвэр гаргагчдыг цаг хугацаанаас үл хамааран бодит цагийн мэдээллээр шууд хангах боломжийг бүрдүүлэх, аймгийг ухаалгаар удирдах, оновчтой хурдан шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх;

2.6. Орон нутагт хүний нөлөөллөөс бага хамааралтай, авлигаас ангид цомхон, чадварлаг төрийн албыг бий болгоход чиглэсэн байх;

2.7. Онцгой байдал, гамшгийн бэлэн байдал, аюулгүй байдлыг хангахад дэмжлэг болох;

2.8. Төрийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийн бүтээлч хамтын ажиллагаа, санаачилга, орон нутагт дэвшилтэт технологи нутагшуулахад чиглэсэн гэрээ, концесс, хувийн хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих;



Гурав. Хөтөлбөрийн зорилго

3.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлэх төрийн үйлчилгээг хялбаршуулах, төрийн дотоод үйл ажиллагааг цахимжуулах, төр, иргэн, аж ахуйн нэгж хоорондын мэдээллийн урсгалыг сайжруулах, цахим технологид түшиглэн иргэдийн амьдралын хэв маягийг хялбаршуулах, цаг хугацааг хэмнэх, зардлыг бууруулах, бүтээмжийг нэмэгдүүлэх, хүний хөгжлийг дэмжихэд хөтөлбөрийн зорилго оршино.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

4.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх ашгийг дээдэлсэн, үйл ажиллагааны харилцаа холбоог сайтар хангасан, мэдээллийн нэгдсэн орчин бүрдүүлсэн, захиргааны цомхон бүтэцтэй ажиллаж болохоор, үр дүнг чухалчилсан, ажлын бүтээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн байх;

4.2. Олон нийтэд ил тод харагдахуйц, хэмжигдэхүйц байх;

4.3. Төр, хувийн хэвшлийн түншлэл, хувийн хөрөнгө оруулалтад түшиглэн хэрэгжүүлэх;

4.4. Хувийн хэвшлийн компани нь тухайн цахим үйлчилгээг үзүүлэх боломжтой, шаардлагатай технологийг эзэмшиж байвал дахин захиалж, давхардсан хөрөнгө оруулалт хийхгүйгээр Mindgolia программ хангамжийн их дэлгүүрээс зах зээлийн зарчмаар худалдан авах;

Тав. Хөтөлбөрийн хугацаа: 2023-2026 он

Эхний үе шат: 2023-2024 он

Хоёрдугаар үе шат: 2024-2025 он

Гуравдугаар үе шат: 2025-2026 он

1-р үе шат: Орон нутгийн цахим шилжилтийн суурь нэгдсэн дата мэдээлэл хадгалах, байршуулах үүлэн тооцооллын дэд бүтцийг байгуулах;

2-р үе шат: Аймгийн хэмжээний тусдаа ажилладаг системүүдийг удирдлагын нэгдсэн цахим хяналтын самбарт холбох, цаашлаад системийн хяналтын хэсгийг хөгжүүлэх, бусад системүүдтэй холбогдох боломж, нөхцөлийг бүрдүүлэх;

3-р үе шат: Төр, иргэн, аж ахуйн нэгж байгууллага хоорондын холбоо хамаарлыг бүрэн цахимд шилжүүлж, олон нийтийн хяналтын хэсгийг бүрдүүлэн удирдлагын нэгдсэн цахим хяналтын самбарт өргөтгөлийг хийж гүйцэтгэх;

Зургаа. Цахимжуулалтын суурь өнөөгийн нөхцөл байдал

Дорноговь аймаг нь 14 сум, 65 багтай бөгөөд 71.9 мянган хүн амтай, 20.1 мянган өрхтэй. Аж үйлдвэрийн 4 дүгээр хувьсгал болон дэлхий нийтээрээ цахим шилжилтэд шилжиж буй өнөө үед харилцаа холбоо, мэдээллийн технологийн

дэвшил нь хөгжлийн хурдасгуур, цахим үндэстнийг цогцлоон хөгжүүлэх гол хүчин зүйл болж байна.

Цахим засаглал: Цахим засаглалыг хөгжүүлэх, холбогдох зорилтуудыг хэрэгжүүлж ирсэн боловч төрийн удирдлагын манлайлал, төрийн байгууллагуудын уялдаа холбоо үүрэг, оролцоо хангалтгүй, нэгдсэн зохицуулалтгүй, үр ашиг багатай зэргээс шалтгаалж цахим шилжилтийн явц удааширч 2 жил тутамд гардаг олон улсын цахим хөгжлийн индексээр 2016 онд 84, 2020 онд 92 дугаар байрт орсон байна.

Мөн Нийтийн мэдээллийг ил тод байдлын тухай, Цахим гарын үсгийн тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиуд 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр батлагдсан нь мэдээллийн аюулгүй байдал, цахим орчинд зөв зохистой хэрэглээ, цахим засаглалыг эрчимжүүлэхэд дээрх асуудлыг шийдвэрлэж, цахим засаглалын хөгжлийг хурдасгах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

Аймгийн хэмжээнд “Алсын хараа -2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэхээр Дорноговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын “Хөгжлийн төлөө хамтдаа” 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дараах зорилтуудыг хэрэгжүүлж байна.

Цахим Монгол: (иргэн, төр, хувийн хэвшлийн нэгдсэн систем)

1.1. Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан, үр дүнтэй цахим засаглалын бодлогыг хэрэгжүүлж, төрийн үйлчилгээний цахим хэрэглээг нэмэгдүүлнэ.

1.2. Төрийн байгууллага хоорондын болон төр, хувийн хэвшлийн байгууллагуудын мэдээллийн солилцоог сайжруулж, төрийн үйлчилгээний цахим хэрэглээг нэмэгдүүлнэ.

1.3. Төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд, олон нийтийн саналыг цахимаар авах, хянах нөхцөлийг бүрдүүлнэ.

“Цахим Монгол” төрийн шуурхай үйлчилгээ

2.1. Төрийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, төрийн цахим үйлчилгээг хөгжүүлнэ.

2.2. Төрийн байгууллагуудад цахим хэрэглээг үе шаттай нэвтрүүлж, мэдээллийг шуурхай солилцох нөхцөлийг сайжруулна.

2.3. Мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшлийг төрийн үйлчилгээнд нэвтрүүлж иргэд, байгууллагад үзүүлэх төрийн үйлчилгээг цахимжуулан хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.4. Төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг сайжруулж, иргэд, олон нийтийн оролцоог хангана. Дээрх бодлогын 2 зорилт, 5 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хүний нөөц: Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 377 дугаар тогтоолын дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоонд “Төрийн үйлчилгээ-мэдээллийн төв”-ийг 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, төрийн үйлчилгээний “ТҮ-7”-1, “ТҮ-6” ангилал, зэрэглэлээр 2 албан хаагчдыг Цахим хөгжил, харилцаа холбооны чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Дорноговь аймгийн Замын-Үүд, Сайншанд сумын төрийн үйлчилгээний нэгдсэн төвд “Төрийн үйлчилгээг операторын горимоор үзүүлэх үйлчилгээ”-г хариуцсан ажилтан байна.

12 сумын Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоонд аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн “Сумдын Засаг даргын Тамгын газрын зарим албан тушаалын ангилал, зэрэглэлд өөрчлөлт оруулах тухай” захирамжаар Дотоод ажил хариуцсан мэргэжилтний албан тушаалыг “Иргэд, олон нийттэй харилцах ажилтан” болгож албан тушаалын ангиллыг ТЗ-3 байсныг ТҮ-7 болгон өөрчлөлт оруулж, албан тушаалын жишиг албан тушаалын тодорхойлолтыг баталсан.

Аймгийн Засаг даргын Тамгын газар болон 14 сумын Засаг даргын Тамгын газарт “Төрийн үйлчилгээг операторын горимоор үзүүлэх үйлчилгээ”-г хариуцан ажиллах албан хаагчдыг ажлын байранд нь сурган чадавхжуулж, төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны нэгдсэн системийг нэвтрүүлэх, цахим шилжилттэй холбоотой үйл ажиллагааны хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Төрийн байгууллагын нэгдсэн систем: “Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем”-ийг 2021 онд 48 байгууллагад, 2022 онд 80 байгууллагад нэвтрүүлэн нийт 128 төрийн болон төрийн өмчит байгууллага албан бичиг солилцох, цаг бүртгэл болон бусад чиглэлээр дотооддоо ашиглаж байгаа нь аймгийн хэмжээнд 89.0 хувьтай байна.

№	Байгууллагын нэр	Төсөвт	Төрийн өмчит
1.	Айраг сум	4	-
2.	Алтанширээ сум	4	-
3.	Дэлгэрэх сум	6	-
4.	Даланжаргалан сум	6	-
5.	Иххэт сум	6	-
6.	Замын-Үүд сум	15	6
7.	Сайхандулаан сум	2	-
8.	Сайншанд сум	21	10
9.	Улаанбадрах сум	6	-
10.	Хатанбулаг сум	2	-

11.	Хөвсгөл сум	3	-
12.	Өргөн сум	3	-
13.	Мандах сум	6	-
14.	Эрдэнэ сум	6	-
15.	Аймгийн төв	36	8
Нийт		128	



Төрийн цахим үйлчилгээ: Замын-Үүд суманд 1, Сайншанд суманд 2 ширхэг Төрийн үйлчилгээний "ТҮЦ" машинаас гаргасан лавлагаа, үйлчилгээг 2021, 2022 оны байдлаар харьцуулан үзэхэд хамгийн их авсан үйлчилгээ нь иргэний үнэмлэхийн лавлагаа гаргасан байна.

№	2021 оны үйлчилгээний статистик мэдээлэл		№	2022 оны үйлчилгээний статистик мэдээлэл	
	үйлчилгээний төрөл	үйлчилгээ үзүүлсэн тоо		үйлчилгээний төрөл	үйлчилгээ үзүүлсэн тоо
1.	Иргэний үнэмлэхийн лавлагаа	2172	1.	Иргэний үнэмлэхийн лавлагаа	2332
2.	Нийгмийн даатгал шимтгэл төлөлт	948	2.	Нийгмийн даатгал шимтгэл төлөлт	1102
3.	Оршин суугаа хаягийн тодорхойлолт	843	3.	Оршин суугаа хаягийн тодорхойлолт	678
4.	Жолоодох эрхийн лавлагаа	948	4.	Жолоодох эрхийн лавлагаа	173
5.	Үл хөдлөх хөрөнгийн лавлагаа	872	5.	Үл хөдлөх хөрөнгийн лавлагаа	311
6.	Гэрлэлт бүртгэлтэй тухай лавлагаа	179	6.	Гэрлэлт бүртгэлтэй тухай лавлагаа	238
7.	Эд хөрөнгөтэй эсэх лавлагаа	240	7.	Эд хөрөнгөтэй эсэх лавлагаа	100
8.	Гэрлэлт бүртгэлгүй тухай лавлагаа	153	8.	Гэрлэлт бүртгэлгүй тухай лавлагаа	110
9.	Төрсний бүртгэлийн лавлагаа	168	9.	Төрсний бүртгэлийн лавлагаа	176
10.	Шүүхийн шийдвэрээр төлбөргүй эсэх лавлагаа	91	10.	Шүүхийн шийдвэрээр төлбөргүй эсэх лавлагаа	103
11.	Хуулийн этгээдийн бүртгэлийн лавлагаа	49	11.	Хуулийн этгээдийн бүртгэлийн лавлагаа	35

12.	COVID-19 Урьдчилан сэргийлэх тарилгын гэрчилгээ	46	12.	COVID-19 Урьдчилан сэргийлэх тарилгын гэрчилгээ	20
13.	Мэргэшсэн жолоочийн лавлагаа	31	13.	Мэргэшсэн жолоочийн лавлагаа	21
14.	Тээврийн хэрэгслийн лавлагаа	28	14.	Тээврийн хэрэгслийн лавлагаа	11
15.	Ачааны авто машины зөвшөөрөл	27	15.	Ачааны авто машины зөвшөөрөл	7
16.	Нийгмийн даатгал нэрийн данс	26	16.	Нийгмийн даатгал нэрийн данс	23
17.	Хувьцаа	22	17.	Хувьцаа	68
18.	Хуулийн этгээдийн бүртгэлгүй лавлагаа	13	18.	Хуулийн этгээдийн бүртгэлгүй лавлагаа	25
19.	Гэрлэлт цуцлалтын бүртгэлийн лавлагаа	12	19.	Гэрлэлт цуцлалтын бүртгэлийн лавлагаа	17
20.	Тээврийн хэрэгслийн лавлагаа/ өмнө нь өмчилж байсан	7	20.	Ковид-19 Эмнэлгийн магадлагаа	10
21.	Нийгмийн даатгал тэтгэврийн эрх	6	21.	Валютын ханшийн лавлагаа	7
22.	Нийгмийн даатгал ажил олгогч	5	22.	Дээд боловсролын гэрчилгээний лавлагаа	3
23.	Бүрэн дунд боловсролын гэрчилгээний лавлагаа	2	23.	Их дээд сургуульд суралцаж байгаа лавлагаа	3
24.	Дээд боловсролын гэрчилгээний лавлагаа	1	24.	Нийгмийн даатгал ажил олгогч	3
25.	-	-	25.	Нийгмийн даатгал тэтгэврийн эрх	3
Нийт		4510	Нийт		5579

Аймгийн төрийн үйлчилгээг цахимаар дамжуулан хүргэхээр 15 төрийн байгууллагын 73 үйлчилгээг төрийн цахим үйлчилгээний нэгдсэн (e-mongolia.mn) системд нэвтрүүлсэн. Мөн 14 сумын операторын үйлчилгээгээр дамжуулан нийт 353 үйлчилгээг авах боломжийг бүрдүүлж давхардсан тоогоор нийт 31017 удаа гаргаж үйлчилсэн.

Төрийн үйлчилгээг цахимаар “e-mongolia.mn”, “e-halamj.mn”, “etax.mta.mn”, “e-gazar.gov.mn”, “nd-daatgal.mn” системээр дамжуулан 544 үйлчилгээг давхардсан тоогоор нийт 104,709 иргэн, аж ахуй нэгжид гарган үзүүлж, заавар зөвлөмжийг өгч ажилласан.

2023 оны 3 сард Төрийн цахим үйлчилгээний “ХУРДАН” төвийг Сайншанд сумын 2 цэгт байгуулан иргэдэд төрийн үйлчилгээг хүргэсэн.

№	Төрөл	Үзүүлэлт	Хүрэх түвшин	2021	2022	Хувь
				хүрсэн түвшин		
1.	Төрийн үйлчилгээ	Аймгийн e-mongolia.mn-д орсон үйлчилгээний тоо	-	-	75	-
2.		Нийт цахимд шилжсэн үйлчилгээний тоо	-	-	544	-
3.		Нийт цахимаар үзүүлсэн үйлчилгээний тоо	-	2202	104709	100
4.		ТҮЦ машинаар гаргасан лавлагааны тоо	-	4510	5579	-
5.	Төрийн байгуул агуудын уялдаа холбоог сайжруул ах чиглэлээр	ERP системд бүртгэсэн байгууллагын тоо	175	55	128	72 хувь
6.		ERP системийг дотооддоо ашиглаж буй байгууллагын тоо	128	48	80	89 хувь
7.		Албаны цахим хуудастай байгууллагын тоо	84	48	58	69 хувь
8.		Тоон гарын үсэг олгосон иргэдийн тоо	10,026	1915	6062	60 хувь
9.		Тоон гарын үсэг олгосон төрийн албан хаагчийн тоо	1400	150	178	12 хувь

Төрийн үйлчилгээний лавлах “call center” үйлчилгээг нэвтрүүлж, аймгийн Засаг даргын Тамгын газарт (7052-1111), Төрийн цахим үйлчилгээ, Нээлттэй Дорноговь лавлах утас (7070-7010), Замын-Үүд суманд (7777-5525) суурин утсыг ажиллуулж, нэг дороос төрийн болон төрийн өмчит 18 байгууллагын 45 төрийн үйлчилгээний талаарх мэдээлэл авах нөхцөлийг бүрдүүлж, нийт 1100 дуудлагад хариу өгсөн.

Орон нутгийн насанд хүрсэн иргэдийн тоог цахим үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоотой харьцуулахад 31.36 хувь нь төрийн үйлчилгээг цахимаар авч зохих үйлчилгээг хүртсэн байна.

Төрийн үйлчилгээг хурдан шуурхай иргэдэд үзүүлэх, төрийн байгууллагуудын бүтээмжийг нэмэгдүүлэх, цахимжуулалтын ажлуудыг хийж гүйцэтгэхэд шаардлагатай байгаа харьяа байгууллагуудын техник тоног төхөөрөмжийн судалгааг гарган, 28 нэр төрлийн 276.7 сая төгрөгийн техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлийг хийсэн.

№	Сумын нэр	Компьютерын мэдээлэл					принтерийн тоо				
		тоо	сайн	дунд	муу	шинэчлэх болон авах шаардлага татай	тоо	сайн	дунд	муу	шинэчлэх болон авах шаардлага татай
1.	Айраг сум	29	2	5	18	13	21	6	5	10	11
2.	Алтанширээ сум	20	6	10	4	4	13	2	4	7	7
3.	Даланжаргалан сум	27	15	5	7	7	17	9	5	3	3
4.	Дэлгэрэх сум	13			13	5	11	10		1	1
5.	Иххэт сум	15	11	1	3	3	13	10	-	3	3
6.	Замын-Үүд сум	42	27	8	7	7	31	31	-	-	3
7.	Мандах сум	17	5	7	5	5	12	4	3	5	5
8.	Сайншанд сум	45	10	12	24	24	45	3	13	29	29
9.	Сайхандулаан сум	13	6	4	3	7	11	9	1	1	2
10.	Хатанбулаг сум	17	17	-	-	-	12	12	-	-	-
11.	Хөвсгөл сум	16	13	2	1	1	12	10	2	-	4
12.	Улаанбадрах сум	11	9	2	-	-	11	9	1	1	1
13.	Эрдэнэ сум	19	11	6	2	2	19	10	6	3	3
Нийт дүн		284	132	62	87	78	228	125	40	63	72

Мэдээлэл холбоо: Мэдээлэл технологийн хурдацтай хөгжлийн энэ цаг үед гар утас, интернэт нь хүн амын өдөр тутмын өргөн хэрэглээ болоод байна. Дорноговь аймгийн 14 сумдад /төвийн багт/ өндөр хурдны интернэтийн шилэн кабелийн сүлжээ нэвтэрсэн. Нийт хүн амын 97.4% интернэтийн сүлжээнд холбогдсон. Орон нутгийн DSB, DTB телевиз, үүрэн телефоны 4 компанийн нийт 8 салбар, 74 агент, 490 гэрээтүүд орон нутагт үйлчилгээ үзүүлж байна. Аймгийн харилцаа холбоо мэдээллийн технологийн салбарын хөгжил өнөөг хүртэлх хугацаанд хөдөө, орон нутагт мэдээлэл, харилцаа холбооны шинэлэг үйлчилгээ нэвтрүүлэх, техник технологийн суурь дэд бүтцийг өргөтгөн шилэн кабелийн сүлжээний урт 1328.02 км байна.

Интернэт хэрэглээ: Аймгийн хэмжээнд хүн амын 6 болон түүнээс дээш насны 87.2 хувь нь гар утас хэрэглэгч, 61.9 хувь нь интернэт хэрэглэгч болжээ. Уг үзүүлэлтийг 2010 оны тооллоготой харьцуулахад гар утас хэрэглэгч 12.9 пунктээр, интернэт хэрэглэгч 38.5 пунктээр тус тус өссөн байна. Интернэт хэрэглэдэг хүн амын 44.3 хувь нь байнга хэрэглэдэг, 55.7 хувь нь шаардлагатай үедээ интернэт хэрэглэдэг байна. Төвд амьдарч буй хүн амын 62.1 хувь нь, хөдөөд амьдарч буй хүн амын 37.9 хувь нь интернэт хэрэглэж байна.

Кибер аюулгүй байдал: Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Улсын их хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д мэдээллийн аюулгүй байдлын үндэсний аюулгүй байдлын нэг бүрэлдэхүүн хэмээн зарлаж, тодорхой зорилтуудыг дэвшүүлсэн.

Улсын Их Хурлаас “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай”, “Кибер аюулгүй байдлын тухай хууль”-ийг 2021 оны 12 сарын 17-нд баталсан нь Монгол улсад кибер аюулгүй байдлыг хангах тогтолцоог бүрдүүлэх үндсэн нөхцөл болж байна.

Тоон бичиг үсэг: Дорноговь аймгийн хэмжээнд 4769 төрийн албан хаагч ажиллаж байгаагаас 3781 төрийн үйлчилгээний, 307 төрийн тусгай, 560, төрийн захиргаа, 121 улс төрийн албан хаагч ажиллаж байна. Үүнээс өнөөдрийн байдлаар 13 байгууллагын 151 албан хаагч тоон гарын үсгийг лавлагаа мэдээлэл гаргах, албан бичиг цахимаар боловсруулах, төрийн сангийн нэгдсэн системд тайлан мэдээ хүргүүлэх байдлаар албан ажилдаа ашиглаж байна. Улсын бүртгэлийн хэлтсээс иргэдэд тоон гарын үсгийг иргэний үнэмлэхэд суулгах ажлыг зохион байгуулж нийт иргэдийн 19,1 хувь буюу 1915 иргэнийг тоон гарын үсэгтэй болгосон. Тоон бичиг үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх, мэдлэг ур чадварыг дээшлүүлэхээр “Цахим гарын үсгийн тухай хууль”-ийг сурталчлах ажлыг 52 аж ахуйн нэгж, байгууллагын албан хаагчид нийт 1331 иргэнийг хамруулсан.

Харин Үндэсний Статистикийн хороо, Харилцаа холбоо мэдээлэл технологийн газрын 2021 онд хамтран хэрэгжүүлсэн “Өрхийн болон хувь хүний мэдээлэл, харилцаа холбоо технологийн хэрэглээ” судалгаанд оролцогчдын сүүлийн 3 сард ашигласан мэдээлэл технологийн хэрэглээнд тулгуурлан үр дүн гаргасан. Нийт судалгаанд оролцогчдын:

- ✓ 43.8% нь мэдээллийн ур чадвартай буюу мэдээлэл хайж олох, үйлчилгээний байгууллагын вэб хуудаснаас мэдээлэл авах, дижитал орчинд өгөгдөл, мэдээлэл, агуулгыг хуулбарлах, шилжүүлэх хэрэгсэл ашиглах, интернэтийн орчинд файл хадгалах,
- ✓ 38.8% хувь нь харилцаа холбооны ур чадвартай буюу интернэтээр утсаар ярих, видео дуудлага хийх, олон нийтийн сүлжээнд оролцох, хавсаргасан файлууд мессеж илгээх, өөрөө бүтээсэн контентоо бусадтай хуваалцах, веб хуудсанд байрлуулах,
- ✓ 27% нь асуудал шийдвэрлэх ур чадвартай буюу интернэт банк хэрэглэх, программ хайх, татаж авч, тохируулах, цахим худалдаа хийх, төхөөрөмжүүд хооронд файл эсвэл программ дамжуулах,
- ✓ 9.8% нь программ хангамжийн ур чадвартай буюу текст боловсруулдаг программ хангамж ашиглах, мэдээллийг цэгцлэх, дүн шинжилгээ хийхэд хүснэгтийн ахисан түвшний функцийг ашиглах, зураг видео эсвэл аудио файлуудыг засварлахад программ ашиглах, илтгэлийн программ хангамж бүхий электрон үзүүлэнг бүтээх, программчлалын хэл дээр код бичих,
- ✓ 6.4% нь аюулгүй байдлын ур чадвартай буюу онлайнаар олж авсан мэдээллийн аюулгүй байдлыг шалгах төхөөрөмж, онлайн хамгаалахын тулд

аюулгүй байдлын үр дүнтэй арга хэмжээг тохируулан хэрэглэх зэрэг чадваруудыг эзэмшсэн байна.

Цахилгаан эрчим хүч: Аймгийн бүх сумд цахилгаан эрчим хүчний нэгдсэн сүлжээнд бүрэг холбогдсон бөгөөд үйл ажиллагааг БЗӨБЦТС ТӨХК-ийн Чойр, Дорноговь салбар, УБТЗ ХНН-ийн ЭХУХ-ийн 2-р анги тус тус хариуцан ажиллаж байна. Цахилгаан эрчим хүчний хэрэглээ, төлбөр тооцооны систем болон хэрэглэгч бүрд ухаалаг тоолуур нэвтрүүлсэн байна.

Дулаан хангамж: Айраг, Алтанширээ, Даланжаргалан, Хатанбулаг, Иххэт, Өргөн, Эрдэнэ, Замын-Үүд, Сайншанд сумд болон Зүүнбаян баг нь төвлөрсөн ус, дулаан хангамжийн шугам сүлжээнд холбогдсон бөгөөд тус сумдын ус, дулаан хангамж, нийтийн аж ахуйн салбарын үйл ажиллагааг “Чандмань-Илч” ХХК, Замын-Үүд дулааны станц, “Сизу” ХХК, УБТЗ ХНН-ийн ЭХУХ-ийн 2-р анги- БАҮ-ний 3-р ангиуд тус тус хариуцан ажиллаж байна. Аймгийн Чандмань-Илч ХХК-аас дулаан үйлдвэрлэлийн харуулсан цахим систем, ус дамжуулах, түгээх байрнуудын цахим систем, хяналт удирдлагын самбар байгуулсан, хэрэглэгчийн ус, дулаан, бохир усны хэрэглээний төлбөр тооцооны системийг нэвтрүүлсэн.

Долоо: Хөтөлбөрийн зорилт

- 7.1. “Ухаалаг засаглал”,
- 7.2. “Ухаалаг төрийн үйлчилгээ”,
- 7.3. “Ухаалаг иргэн”,
- 7.4. “Ухаалаг орчин” зорилтын хүрээнд хэрэгжүүлнэ.

Найм: Хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээ

8.1. “Ухаалаг засаглал” төрийн дотоод үйл ажиллагааг цахимжуулж уялдаа холбоог сайжруулах, төр, иргэн, аж ахуй нэгж хоорондын мэдээллийн урсгалыг сайжруулах, кибер аюулгүй байдлыг хангасан чадварлаг боловсон хүчнийг бэлтгэж нэгдсэн удирдлагын платформыг бий болгож ухаалаг засаглалын тогтолцоо бүрдүүлэх нэгдүгээр зорилтын хүрээнд:

8.1.1. Төрийн дотоод үйл ажиллагаанд “Төрийн байгууллагын дотоод удирдлагын нэгдсэн “ERP” системийг бүрэн нэвтрүүлж, тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх;

8.2.2. Иргэн, аж ахуйн нэгж, төрийн байгууллагын мэдээллийг нэг дороос авах нөхцөлийг бүрдүүлж аймгийн цахим хуудас, “Нээлттэй Дорноговь” гар утас аппликейшнийг бүтээх;

8.2.3. Төрийн албан хаагчдын мэдээллийн технологийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтыг үе шаттай зохион байгуулах;

8.2.4. Аймгийн удирдлагын нэгдсэн системийн мэдээллийн өгөгдөл болон бусад системийн мэдээллийг хадгалах, найдвартай байдлыг хангах тоног төхөөрөмж буюу серверийг хосолсон байдлаар ашиглах боломжийг бүрдүүлэн Үндэсний дата төв УТҮГ-т байршуулах;

8.2.5. Төрийн байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдлын үнэлгээг мэргэжлийн байгууллагатай хамтран хийж гүйцэтгэх;

8.2.6. Засаг захиргааны анхан шатны нэгжийн тоног төхөөрөмжийг шинэчлэх;

8.2. **“Ухаалаг төрийн үйлчилгээ”** иргэн, аж ахуйн нэгжид үзүүлэх төрийн үйлчилгээг хялбаршуулж санал, хүсэлт, гомдлыг цахимаар хүлээн авах, санал асуулгын оролцооны цахим системийг хөгжүүлж, цаг хугацааг хэмнэх, зардлыг бууруулах, бүтээмжийг нэмэгдүүлэх хоёрдугаар зорилтын хүрээнд:

8.2.1. Аймгаас үзүүлж байгаа төрийн үйлчилгээг e-mongolia.mn төрийн нэгдсэн цахим системд холбох;

8.2.2. Иргэн, аж ахуйн нэгжид үзүүлэх төрийн үйлчилгээг цахимаар авах боломжийг нэмэгдүүлж үйлчилгээний төвлөрсөн цэгүүдэд КИОСК машин, “ХурДан” цэгийн тоог нэмэгдүүлэх;

8.2.3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг нэгдсэн үйлчилгээний платформд нэгтгэх ажлыг хувийн хэвшилтэй хамтран хийж гүйтэцгэх;

8.2.4. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг үнэлэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ өгөх, өргөдөл, гомдол, санал хүсэлтийг цахимаар хүлээн авах, хянах, шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлэх;

8.2.5. Яаралтай тусламж үйлчилгээг иргэдийн байгаа газыг gps-ийн тусламжтайгаар тодорхойлон хурдан шуурхай арга хэмжээ авч ажиллах ухаалаг шийдлийг нэвтрүүлэх;

8.2.6. Эрүүл мэндийн системүүдийг аймгийн удирдлагын нэгдсэн цахим хяналтын самбартай холболт хийж хянадаг цахим системийг хөгжүүлэх;

8.3. **“Ухаалаг иргэн”** цахим орчинд болон технологийг зөв зохистой хэрэглэх мэдлэг олгох, цахим ур чадварыг нэмэгдүүлж, цахим соёлыг төлөвшүүлэх, сургалтын цахим системийг нэвтрүүлэх гуравдугаар зорилтын хүрээнд:

8.3.1. Цахим хэрэглээ, төрийн үйлчилгээ, мэдээллийг иргэд, олон нийтэд цахимаар авах мэдлэг олгох сургалт, сурталчилгааны ажлыг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах;

8.3.2. Хүүхдүүдийн дунд техник технологи, программ хангамжийн тэмцээнийг хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах;

8.3.3. Мэдээллийн технологийн чиглэлээр суралцаж байгаа оюутан залуучуудад сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлж, орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулах;

8.4. **“Ухаалаг орчин”** технологийн дэвшлийг ашиглаж, иргэдийн тав тухтай, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, оновчтой ухаалаг шийдлүүдийг нэвтрүүлэх дөрөвдүгээр зорилтын хүрээнд:

8.4.1. Интернэтийн үйлчилгээг нийтийн эзэмшлийн талбайнуудад хүргэж утасгүй интернэтийн цэгүүдийг нэмэгдүүлэх;

8.4.2. Олон нийтийн гудамж, зам, талбайн эрсдэлтэй газруудад камержуулах ажлыг хийж гүйцэтгэн камерын мэдээллийг хадгалах, царай болон дүрс танилтын системийг нэвтрүүлэх;

8.4.3. Аялал жуулчдад зориулсан үйлчилгээ болон газрын байршил зэрэг цогц мэдээллийг багтаасан цахим платформыг бий болгох;

8.4.4. Сууц өмчлөгчдийн холбооны цэвэрлэгээ, үйлчилгээ, тохижилтын үйл ажиллагаанд хяналт тавих нэгдсэн системийг бүтээх;

8.4.5. Багийн ажлын алба, айл өрх, иргэд хоорондын уялдааг сайжруулах, мэдээ, мэдээлэл солилцох системийг нэвтрүүлэх;

8.4.6. Тээвэр логистик, шалган нэвтрэлтийн процессыг олон нийтэд нээлттэй хяналтыг бий болгох цахим системийг нэвтрүүлэн нэгдсэн удирдлагатай цогц платформыг бүтээх;

8.4.7. Хот тохижилтын удирдлагын нэгдсэн системийг нэвтрүүлэх;

Ес. Хөтөлбөр хэрэгжүүлэх арга зам, санхүүжилт

9.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн бодлого, удирдамжаар хангах ажлыг аймгийн Засаг даргын Тамгын газар хариуцан зохион байгуулах ба бөгөөд хамтран хэрэгжүүлэгч нь Төрийн цахим үйлчилгээний хэлтэс байна.

9.2. Төрийн болон төрийн өмчит байгууллагууд нь технологийн дэвшил, ухаалаг шийдлүүдийг нэвтрүүлж, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэн, үйлчилгээний чанар хүртээмж, шуурхай байдлыг хангаж ажиллана.

9.3. “Хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г аймгийн Засаг даргаар батлуулан хэрэгжүүлнэ.

9.4. Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг цахим шилжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж, үр дүнг тооцно.

Арав. Хөтөлбөрийн санхүүжилт


10.1. Хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүр улс, орон нутгийн төсвийн санхүүжилт болон бусад эх үүсвэрээр санхүүжүүлнэ. Үүнд:

- 10.1. Улсын төсвийн хөрөнгө
- 10.2. Орон нутгийн төсвийн хөрөнгө
- 10.3. Олон улсын байгууллагын зээл, тусламж
- 10.4. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт
- 10.5. Бусад эх үүсвэр

Арван нэг: Хөтөлбөрийн үр дүн

“Цахим Дорноговь” хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хүрэх үр дүнг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

- ✓ Цахим технологийг нийгэм, эдийн засаг, засаглал, байгаль орчны чиглэлээр өргөн хүрээнд нэвтрүүлнэ.
- ✓ Иргэдийн амьдрах болон ажиллах орчныг өөрчлөхийн тулд цахим технологийг нэвтрүүлсэн байна.
- ✓ Төрийн байгууллага, төрийн үйлчилгээнд цахимжилт өргөн нэвтэрсэн байна.
- ✓ Орон нутгийн цахим засаглалыг дэмжсэн, их өгөгдлүүдийг бүрдүүлсэн системүүд хөгжсөн байна.

- 
- ✓ Орон нутгийн салбар бүрийн иргэнээс төрд, төрөөс иргэн, хувийн хэвшилд чиглэсэн бүхий л төрийн их өгөгдөлд суурилсан мэдээллийг боловсруулан, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлж, төрийн захиргааны байгууллагууд болон иргэд хоорондын итгэлцэл, ил тод байдал бий болсон байна.
 - ✓ Орон нутгийн удирдлагын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, бодитой, хэмжигдэхүйц, тоон мэдээллээр бодит цагийн горимд хангах техникийн боломж бүрдсэн байна.
 - ✓ Орон нутгийн орон зайн мэдээллийн систем бий болж, иргэдийг шаардлагатай мэдээллээр хангадаг болсон байна.
 - ✓ Иргэн, аж ахуйн нэгжүүдийн бизнес эрхлэхтэй холбоотой төрөөс үзүүлж буй үйлчилгээний бүхий л мэдээллийг нэг цэгт төвлөрүүлэн харуулах боломж бүрдсэн байна.
 - ✓ Иргэдийн цахим ур чадвар, чадамжийг дээшлүүлэх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлдэг болсон байна.

---o0o---

9.5. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Д/д	Хөтөлбөрт тусгагдсан зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх үр дүн	Хэрэгжүүлэх хугацаа				Төсөв /сая/	Төсвийн эх үүсвэр
				2023	2024	2025	2026		
1.	Ухаалаг засаглал	Төрийн дотоод үйл ажиллагаанд "Төрийн байгууллагын дотоод удирдлагын нэгдсэн "ERP" системийг бүрэн нэвтрүүлж, тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх;	Төрийн дотоод үйл ажиллагаа цахимжиж уялдаа холбоо сайжирсан байна.	+	+	+	+	60,0	УТ, ОНТХ, ОУБЗТ, ХХХО, Бусад
2.		Иргэн, аж ахуйн нэгж, төрийн байгууллагын мэдээллийг нэг дороос авах нөхцөлийг бүрдүүлж аймгийн цахим хуудас, "Нээлттэй Дорноговь" гар утас аппликейшнийг бүтээх;	Төр, иргэн, аж ахуй нэгж хоорондын мэдээллийн урсгал хурдан шуурхай болсон байна. Кибер аюулгүй байдлыг хангасан чадварлаг боловсон хүчнийг бэлтгэж нэгдсэн удирдлагын платформ бий болж ухаалаг засаглалын тогтолцоо бүрдсэн байна.	+	+	+	+	150,0	УТ, ОНТХ, ОУБЗТ, ХХХО, Бусад
3.		Төрийн албан хаагчдын мэдээллийн технологийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтыг үе шаттай зохион байгуулах;	Урсгал хурдан шуурхай болсон байна. Кибер аюулгүй байдлыг хангасан чадварлаг боловсон хүчнийг бэлтгэж нэгдсэн удирдлагын платформ бий болж ухаалаг засаглалын тогтолцоо бүрдсэн байна.	+	+	+	+	15,0	УТ, ОНТХ, ОУБЗТ, ХХХО, Бусад
4.		Аймгийн удирдлагын нэгдсэн системийн мэдээллийн өгөгдөл болон бусад системийн мэдээллийг хадгалах, найдвартай байдлыг хангах тоног төхөөрөмж буюу серверийг хосолсон байдлаар ашиглах боломжийг бүрдүүлэн Үндэсний дата төв УТҮГ-т байршуулах;	Урсгал хурдан шуурхай болсон байна. Кибер аюулгүй байдлыг хангасан чадварлаг боловсон хүчнийг бэлтгэж нэгдсэн удирдлагын платформ бий болж ухаалаг засаглалын тогтолцоо бүрдсэн байна.	+	+	+	+	400,0	УТ, ОНТХ, ОУБЗТ, ХХХО, Бусад
5.		Төрийн байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдлын үнэлгээг мэргэжлийн байгууллагатай хамтран хийж гүйцэтгэх;	Урсгал хурдан шуурхай болсон байна. Кибер аюулгүй байдлыг хангасан чадварлаг боловсон хүчнийг бэлтгэж нэгдсэн удирдлагын платформ бий болж ухаалаг засаглалын тогтолцоо бүрдсэн байна.	+	+	+	+	80,0	УТ, ОНТХ, ОУБЗТ, ХХХО, Бусад

6.		Засаг захиргааны анхан шатны нэгжийн тоног төхөөрөмжийг шинэчлэх;		+	+	+	+	275,0	УТ, ОНТХ, ОУБЗТ, ХХХО, Бусад
7.	Ухаалаг терийн үйлчилгээ	Аймгаас үзүүлж байгаа төрийн үйлчилгээг e-mongolia.mn төрийн нэгдсэн цахим системд холбох;		+	+	+	+	10,0	УТ, ОНТХ, ОУБЗТ, ХХХО, Бусад
8.		Иргэн, аж ахуйн нэгжид үзүүлэх төрийн үйлчилгээг цахимаар авах боломжийг нэмэгдүүлж үйлчилгээний төвлөрсөн цэгүүдэд КИОСК машин, "ХурДан" цэгийн тоог нэмэгдүүлэх;	Иргэн, аж ахуйн нэгжид үзүүлэх төрийн үйлчилгээ авхад хялбар болж санал, хүсэлт, гомдол, санал асуулгыг цахимаар өвөх нөхцөл бүрдсэн байна.	+	+	+	+	50,0	УТ, ОНТХ, ОУБЗТ, ХХХО, Бусад
9.		Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг нэгдсэн үйлчилгээний платформд нэгтгэх ажлыг хувийн хэвшилтэй хамтран хийж гүйцэтгэх;		+	+	+	+	100,0	УТ, ОНТХ, ОУБЗТ, ХХХО, Бусад
10.		Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг үнэлэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ өгөх, өргөдөл, гомдол, санал хүсэлтийг цахимаар хүлээн авах, хянах, шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлэх;	Төр, иргэн, аж ахуйн нэгжийн цаг хугацааг хэмнэгдэж бүтээмж нэмэгдсэн байна.	+	+			80,0	УТ, ОНТХ, ОУБЗТ, ХХХО, Бусад
11.		Яаралтай тусламж үйлчилгээг иргэдийн байгаа газыг grs-ийн тусламжтайгаар тодорхойлон хурдан шуурхай арга хэмжээ авч ажиллах ухаалаг шийдлийг нэвтрүүлэх;		+	+			200,0	УТ, ОНТХ, ОУБЗТ, ХХХО, Бусад
12.		Эрүүл мэндийн системүүдийг аймгийн удирдлагын нэгдсэн цахим хяналтын			+	+		60,0	УТ, ОНТХ, ОУБЗТ,

	самбартай холболт хийж хянадаг цахим системийг хөгжүүлэх;									XXHO, Бусад
13.	Цахим хэрэглээ, төрийн үйлчилгээ, мэдээллийг иргэд, олон нийтэд цахимаар авах мэдлэг олгох сургалт, сурталчилгааны ажлыг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах;	Цахим орчинд ажиллах мэдлэг иргэдийн мэдлэг дээшилсэн байна.	+	+	+	+	+	80,0	УТ, ОНТХ, ОУБЗТ, XXHO, Бусад	
14.	Хүүхдүүдийн дунд техник технологи, программ хангамжийн тэмцээнийг хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах;	Цахим ур чадварыг нэмэгдүүлж цахим соёл нэвтэрсэн сургалтын цахим системийг нэвтрүүлэх	+	+	+	+	+	10,0	УТ, ОНТХ, ОУБЗТ, XXHO, Бусад	
15.	Мэдээллийн технологийн чиглэлээр суралцаж байгаа оюутан залуучуудад сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлж, орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулах;		+	+	+	+	+	30,0	УТ, ОНТХ, ОУБЗТ, XXHO, Бусад	
16.	Интернэтийн үйлчилгээг нийтийн эзэмшлийн талбайнуудад хүргэж утасгүй интернэтийн цэгүүдийг нэмэгдүүлэх;	Иргэдийн тав тухтай, аюулгүй орчинд амьдрах нөхцөл бүрдүүлсэн байна. Ухаалаг шийдлүүдийг нэвтэрсэн байна.	+	+	+	+	+	150,0	УТ, ОНТХ, ОУБЗТ, XXHO, Бусад	
17.	Олон нийтийн гудамж, зам, талбайн эрсдэлтэй газруудад камержуулах ажлыг хийж гүйцэтгэн камерын мэдээллийг хадгалах, царай болон дүрс танилтын системийг нэвтрүүлэх;		+	+	+	+	+	300,0	УТ, ОНТХ, ОУБЗТ, XXHO, Бусад	
18.	Аялал жуулчдад зориулсан үйлчилгээ болон газрын байршил зэрэг цогц мэдээллийг багтаасан цахим платформ бий болгох;			+	+	+	+	100,0	УТ, ОНТХ, ОУБЗТ, XXHO, Бусад	

19.	Сууц өмчлөгчдийн холбооны цэвэрлэгээ, үйлчилгээ, тохижилтын үйл ажиллагаанд хяналт тавих нэгдсэн системийг бүтээх;		+	+			100,0	УТ, ОНТХ, ОУБЗТ, ХХХО, Бусад
20.	Багийн ажлын алба, айл өрх, иргэд хоорондын уялдааг сайжруулах, мэдээ, мэдээлэл солилцох системийг нэвтрүүлэх;			+	+		80,0	УТ, ОНТХ, ОУБЗТ, ХХХО, Бусад
21.	Тээвэр логистик, шалган нэвтрэлтийн процессийг олон нийтэд нээлттэй хяналтыг бий болгох цахим системийг нэвтрүүлэн нэгдсэн удирдлагатай цогц платформыг бүтээх;		+	+			150,0	УТ, ОНТХ, ОУБЗТ, ХХХО, Бусад
22.	Хот тохижилтын удирдлагын нэгдсэн системийг нэвтрүүлэх;		+	+	+		300,0	УТ, ОНТХ, ОУБЗТ, ХХХО, Бусад
Нийт дүн							2,780,0	